



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/337

Булган сум

**Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх
тусгай зөвшөөрлийн тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1, 8.1 дүгээр зүйлийн 12 дугаар хэсгийн 12.13, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан “Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтын журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл” олгох цэгийн нэрийг 1 дүгээр, амралт аялал жуулчлалын улирал эхэлж байгаатай холбогдуулан 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс 08 дугаар сарын 25-ныг хүртэл 24 цагаар үйл ажиллагаа эрхлэх цэгийн нэрийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/578 дугаар захирамжийн Ө.Чинбат захиралтай “Хавтгайн бэл” ХХК-ийн “Хөшөөт гол” хүнсний дэлгүүртэй холбогдох заалтыг хүчингүйд тооцсугай.

3. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.1, 35.2.2-т заасан тэмдэгтийн хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг сумын Засаг дарга, Татварын газар (Д.Лхагвасүрэн), Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Давааням)-т тус тус даалгасугай.

4. Дээрх цэгүүдийн үйл ажиллагаанд холбогдох хууль, журам, стандартуудын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (хурандаа Б.Эрдэнэбилэг), Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Шүрэнцэцэг), Стандарт, хэмжил зүйн хэлтэс (Д.Алтаншагай), сумын Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Сугаа Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010533

Аймгийн Засаг даргын 2025 оны
05 дугаар сарын 20-ны/ний өдрийн
А/337 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН НЭР СОЛИХ ЦЭГИЙН НЭРС

д/д	Сумын нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигч		Үйлчилгээний төрөл	Оноосон нэр, хаяг байршил	Шинээр тусгай зөвшөөрөл эзэмших		Оноосон нэр, хаяг байршил
		Аж ахуйн нэгжийн нэр	Захирлын овог, нэр			Аж ахуйн нэгжийн нэр	Захирлын овог, нэр	
1	2	3	4	5	6	7	8	9
1	Хишиг-Өндөр	"Хавтгайн бэл" ХХК	Ө.Чинбат	Хүнсний дэлгүүр	"Хөшөөт гол" 5-р баг 10-р гудамж 1000-1022 тоот	"Хавтгайн бэл" ХХК	Д.Булгантамир	"Баялаг" 5-р баг 10-р гудамж 1000 тоот
	Нийт-1							

Аймгийн Засаг даргын 2025 оны
05 дугаар сарын 20-ны/ний өдрийн
А/337 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

Амралт, аялал жуулчлалын улирал эхэлсэнтэй холбогдуулан
2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс 08 дугаар сарын 25-ныг хүртэл
24 цагийн хугацаанд спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа
худалдах цэгийн нэр

д/д	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн овог, нэр	Үйлчилгээний төрөл	Бар, ресторан, дэлгүүрийн нэр
1	2	3	4	5	6
1	Булган сум	"Премиум Нэксус" ХК	Г.Чинзориг	Хүнсний дэлгүүр	"CU432"
Нийт-1					